

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Иргэний нисэхийн тухай хуульд доор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1\3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэг:

“3.2. Монгол Улс өөрийн нутаг дэвсгэрийн агаарын орон зайд төгс, онцгой бүрэн эрхтэй. Монгол Улсын нутаг дэвсгэрт хамаарах агаарын орон зайд Монгол Улсын иргэний нисэхийн дүрэм үйлчлэх бөгөөд уг орон зайд нислэг үйлдэх, маневр хийх аливаа агаарын хөлөг иргэний нисэхийн дүрэм, холбогдох журмыг дагаж мөрдөх үүрэг хүлээнэ.”

2\5 дугаар зүйлийн 5.1.21-5.1.25 дахь заалт:

“5.1.21. “зорчигч” гэж арилжааны нислэгийн хувьд тээвэрлэлтийн гэрээний дагуу агаарын хөлөгт зорчиж байгаа этгээдийг; арилжааны бус нислэгийн хувьд агаарын хөлөгт зорчиж байгаа, нисгэгчээс бусад этгээдийг;

5.1.22. “Монгол Улсын нутаг дэвсгэр” гэж Монгол Улсын хилийн тухай¹ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д заасныг;

5.1.23. “нисэхийн баримт бичиг” гэж аливаа этгээд, агаарын хөлөг, аэродром, нисэхийн журам, нисэхийн бүтээгдэхүүн, эсхүл нисэхийн холбоотой үйлчилгээний хувьд энэ хууль, иргэний нисэхийн дүрмийн дагуу олгосон үнэмлэх, гэрчилгээ, зөвшөөрөл, эсхүл бусад баримт бичгийг;

5.1.24. “ноцтой хэрэг” гэж агаарын хөлгийн үйл ажиллагаатай холбоотой, хүнтэй агаарын хөлгийн хувьд, нислэгийн зорилгоор аливаа этгээд агаарын хөлөгт орсон цагаас эхлээд тухайн этгээд буух цаг хугацааны хооронд болсон, эсхүл хүнгүй агаарын хөлгийн хувьд, тухайн нислэгийн зорилгоор агаарын хөлөг хөдлөхөд бэлэн болсон цагаас эхлээд нислэгийн төгсгөлд зогсож, үндсэн хөдөлгүүрээ унтраах хүртэлх хугацааны хооронд болсон, осол болох өндөр магадлалтай нөхцөлд гарсан хэргийг;

5.1.25. “улсын нутаг дэвсгэр” гэж тухайн улсын бүрэн эрхт байдал, ивээл, хамгаалалтад байгаа, эсхүл эрхээ хэрэгжүүлж байгаа хуурай газар болон нутгийн усыг.”

¹Монгол Улсын хилийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2017 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

3\12 дугаар зүйлийн 12.2-12.5 дахь хэсэг:

“12.2.Иргэний нисэхийн дүрэмд дараах тохиолдолд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл шинээр дүрэм гаргана:

12.2.1.конвенцын хавсралтад нэмэлт, өөрчлөлт орсон тухай бүр боломжит хугацаанд;

12.2.2.агаарын хөлгийн осол, хэргийг шинжлэн шалгах албаны эцсийн тайлангийн дагуу нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай нь тогтоогдсон;

12.2.3.иргэний нисэхийн аюулгүй байдлын эрсдэлийг бууруулах хэрэгцээ үүссэн.

12.3.Иргэний нисэхийн дүрмийг шинэчлэн батлах, эсхүл нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд тухайн дүрмийн дагуу эрх, үүрэг үүссэн этгээдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор шаардлагатай гэж үзвэл шилжилтийн үеийн зохицуулалтыг тусгаж болно.

12.4.Нислэгийн аюулгүй байдлын хойшлуулшгүй, эсхүл шилжилтийн цаг үеийн асуудлыг зохицуулах зорилгоор дарга шуурхай дүрэм, тусгай дүрэм гаргаж болно.

12.5.Дүрмийг дагалдан гарах зөвлөмжийн цуврал болон тушаал, бусад техникийн баримт бичгийг салбарын хэмжээнд мөрдөнө.”

4\14 дүгээр зүйлийн 14.6, 14.7 дахь хэсэг:

“14.6.Нислэгт тэнцэх чадварын стандарт гэрчилгээтэйгээр ашиглах агаарын хөлгийг Монгол Улсад бүртгэхээс өмнө дарга тухайн агаарын хөлгийн маягийг хүлээн зөвшөөрсөн байна.

14.7.Иргэний агаарын хөлгийг ашиглалтаас хассан, эсхүл гадаад улсад бүртгүүлэх тохиолдолд Монгол Улсын бүртгэлээс хасна.”

5\15¹, 15² дугаар зүйл:

“15¹ дугаар зүйл. Хүрээлэн буй орчны хамгаалалт

15¹.1.Энэ хуулийн 15.1, 15.2-т заасны дагуу Монгол Улсад маяг нь хүлээн зөвшөөрөгдөх агаарын хөлөг нь конвенцын хавсралт 16-д заасан хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн стандартыг хангасан байна.

15¹.2.Энэ хуулийн 15.1-т заасныг хангасан агаарын хөлгийн хөдөлгүүрийн дуу чимээний гэрчилгээг дарга олгоно.

15² дугаар зүйл.Нисэхийн ажилтанд мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ олгох

15².1.Агаарын хөлгийн нисгэгч, нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний ажилтан, агаарын хөлгийн техник, үйлчилгээний ажилтан, нисэх инженер болон нислэгийн диспатчерийн мэдлэг, ур чадвар, туршлага, эрүүл мэндийн байдал нь холбогдох олон улсын стандарт, Иргэний нисэхийн дүрэм, техникийн баримт бичигт

заасан шаардлагыг бүрэн хангасан тохиолдолд тохирох ангиллын мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ Иргэний нисэхийн ерөнхий газар олгоно.

15².2.Монгол Улстай хэлэлцэн тохиролцогч улсаас олгосон мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээг хүчин төгөлдөр гэж хүлээн зөвшөөрч болно.

15².3.Монгол Улстай хэлэлцэн тохиролцогч аливаа улсаас хувь хүнд олгосон мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээ нь Монгол Улсын Иргэний нисэхийн дүрэм, холбогдох техникийн баримт бичигт нийцэхгүй тохиолдолд хүлээн зөвшөөрөхөөс татгалзах эрхтэй.

15².4.Конвенцын холбогдох хавсралт, техникийн бичиг баримт, Иргэний нисэхийн дүрэмд өөрчлөлт орсны дараах дахин гэрчилгээжүүлэлт нь уг баримт бичгүүдийг шинэчлэн батлагдсан өдрөөс нэг жилийн өмнөх хугацаанд олгосон мэргэжлийн үнэмлэх, зэрэглэл, эрүүл мэндийн гэрчилгээнд хамаарахгүй бөгөөд тухайн баримт бичгүүдийг олгогдсон хугацаагаар хүчин төгөлдөр хэвээр тооцно.”

6\17¹, 17², 17³,17⁴ дүгээр зүйл:

“17¹ дугаар зүйл.Хүнгүй агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагаа

17¹.1.Хүнгүй агаарын хөлгөөр газрын гадаргуу, эсхүл усны мандлаас 120 метрээс илүү өндөрт Агаарын навигацийн үйлчилгээний байгууллагын зөвшөөрөлгүйгээр нислэг үйлдэхийг хориглоно.

17¹.2.Хүнгүй агаарын хөлгөөр нисэх буудал болон бусад агаарын навигацид ашиглагдах агаарын зайд нислэг үйлдэх бол Агаарын навигацийн үйлчилгээний байгууллагаас зөвшөөрөл авна.

17¹.3.Хүнгүй агаарын хөлгөөр хориотой агаарын зайд нислэг үйлдэхийг хориглоно.

17¹.4.Хүнгүй агаарын хөлгийг бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулахгүй ашиглах хариуцлагыг үйл ажиллагаа эрхлэгч хүлээнэ. Хэрэв хүнгүй агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч хуулийн хариуцлага хүлээх насанд хүрээгүй бол хариуцлагыг түүний эцэг эх, асран хамгаалагч хүлээнэ.

17² дугаар зүйл.Хувийн нислэг болон нисэх клубийн үйл ажиллагаа

17².1.Хувийн хэрэгцээнд үйлдэгдэх нислэгийн шууд зардлыг зорчигчтой хуваан гаргуулж болох ба агаарын хөлгийн нисгэгч, эсхүл эзэмшигч уг зардлыг хуваан хариуцна.

17².2.Нисэх клубийн үйл ажиллагаанд ашиглах агаарын хөлгийн хувьд танилцах болон хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн ажилтны сургалтын нислэгийн шууд зардлыг клубийн гишүүн, клубийн үйл ажиллагаатай танилцах хүсэлтэй этгээдээс гаргуулж болно.

17³ дугаар зүйл.Адал явдалт нислэгийн үйл ажиллагаа

17³.1. Агаарын бөмбөлөг, шүхэр, параглайдер, дельтаплан болон бусад хэт хөнгөн агаарын хөлгийн нислэгийн үйл ажиллагааг зөвхөн өдрийн цагаар үйлдэнэ.

17³.2. Адал явдалт нислэгийн үйл ажиллагаанаас үүсэх эрсдэлийг тухайн үйл ажиллагаанд оролцогч сайн дураараа хүлээн зөвшөөрсөнд тооцох бөгөөд тухайн оролцогч гэнэтийн ослын даатгалд заавал хамрагдсан байна.

17³.3. Адал явдалт нислэгийн үйл ажиллагаа нь агаарт байгаа бусад агаарын хөлөг, газарт байгаа хүн, эд хөрөнгө, байгалийн өвөрмөц тогтцод хохирол учруулахгүйгээр гүйцэтгэгдэнэ.

17⁴ дугаар зүйл. Онцгой үүрэг

17⁴.1. Төрийн тусгай хамгаалалт бүхий өндөр албан тушаалтан иргэний агаарын хөлгөөр төрийн айлчлал буюу албан ажлаар зорчих онцгой үүргийн нислэгийн журмыг Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга, Төрийн тусгай хамгаалалтын газар, иргэний нисэхийн асуудал хариуцсан засгийн газрын гишүүн хамтарч батална.

17⁴.2. Онцгой үүргийн нислэгийн бэлтгэл, бэлэн байдал, нислэгийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтыг уг нислэгийг гүйцэтгэх агаарын тээвэрлэгч хариуцна.

17⁴.3. Онцгой үүргийн нислэгээр үйлчлүүлэгч албан тушаалтан нислэгийн үед нисэх багийн гишүүдэд нислэгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх, эрсдэл үүсгэж болох аливаа үүрэг, тушаал өгөх эрхгүй.”

7\19 дүгээр зүйлийн 19.2, 19.3 дахь хэсэг:

“19.2. Бусдын эрүүл мэнд, аюулгүй байдал, өмч хөрөнгө, эсхүл хүрээлэн буй орчинд эрсдэл учруулж болзошгүй аюултай барааг агаарын хөлгөөр тээвэрлэх, тээвэрлэлтэд бэлтгэж хүлээлгэн өгөх үйл ажиллагааг Иргэний нисэхийн дүрмийн дагуу зөвшөөрөгдсөн этгээдээр гүйцэтгүүлнэ.

19.3. Иргэний нисэхийн дүрэмд зааснаас бусад тохиолдолд аливаа этгээд агаараар тээвэрлэхийг хориглосон аюултай барааг тээвэрлэхийг санал болгох, эсхүл тээвэрлэлтэд хүлээн авахыг хориглоно.”

8\21 дүгээр зүйлийн 21.6, 21.7 дахь хэсэг:

“21.6. Гадаад улсын нутаг дэвсгэрт болон тухайн улсад харьяалагдах далайн агаарын зайд нислэг үйлдэхдээ тухайн газар нутагт хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Конвенцод нийцсэн дүрэм, журмыг баримтална.

21.7. Агаарын хөлгийн дарга нислэгийн бүртгэлийн дэвтрийг бүрэн хөтлөсөн байна.”

9\21¹ дүгээр зүйл:

“21¹ дүгээр зүйл. Агаарын хөлөгт авч явах баримт бичиг

21¹.1.Аливаа этгээд нь дараах хүчинтэй баримт бичгийг агаарын хөлөгт байршуулан авч яваагүй бол нислэг үйлдэхийг хориглоно.

21¹.1.1.агаарын хөлгийн улсын бүртгэлийн гэрчилгээ;

21¹.1.2.нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, эсхүл тусгай нислэгийн зөвшөөрөл;

21¹.1.3.хэрэв радио төхөөрөмжөөр тоноглогдсон бол агаарын хөлгийн радио холбооны гэрчилгээ;

21¹.1.4.багийн гишүүн бүрийн холбогдох хүчинтэй үнэмлэх;

21¹.1.5.нислэгийн бүртгэлийн дэвтэр, эсхүл түүнтэй дүйцэхүйц баримт;

21¹.1.6.хэрэв зорчигч тээвэрлэж яваа бол тэдний нэрийн жагсаалт, суусан болон очих газар;

21¹.1.7.хэрэв ачаа тээвэрлэж яваа бол тусгай ачааллын мэдээлэл агуулсан ачааны манифест;

21¹.1.8.агаарын тээвэрлэгчийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар болон тухайн агаарын хөлгийн маягт хамаарах үйл ажиллагааны тодорхойлолтын хуулбар;

21¹.1.9.тухайн агаарын хөлгийн дуу чимээний гэрчилгээ;

21¹.1.10.иргэний нисэхийн дүрмээр шаардсан бусад баримт бичиг.”

10123 дугаар зүйлийн 23.1.9 дэх заалт:

“23.1.9.Монгол Улсын нутаг дэвсгэрт үйлдэгдэх нислэгт конвенцын хавсралт 1-ийн дагуу олгогдоогүй үнэмлэх, гэрчилгээ эзэмшигчийг оролцуулах.”

11124 дүгээр зүйлийн 24.3 дэх хэсэг:

“24.3.Үндэсний аюулгүй байдалд онц ноцтой хохирол учруулах эрсдэл үүссэн бөгөөд тухайн нөхцөл нь илэрхий, тулгарсан байхаас бусад тохиолдолд зөрчил гаргасан иргэний агаарын хөлгийн эсрэг зэвсэг хэрэглэхийг хориглоно.”

12125 дугаар зүйлийн 25.4-25.6 дахь хэсэг:

“25.4.Нутгийн захиргааны байгууллага нь аюул тулгарсан агаарын хөлгийн мэдээллийг зохих байгууллагад нэн даруй мэдэгдэх, нисэх баг, зорчигчдын амь насыг аврах, тэдэнд эмнэлгийн болон бусад зайлшгүй тусламж үзүүлэх, агаарын хөлөг, түүний баримт бичгийг хамгаалалтад авах үүрэгтэй.

25.5.Эрэн хайх, авран туслах нислэгийг улсын нисэхийн байгууллагатай хамтран гүйцэтгэж болно.

25.6.Улсын нисэхийн тухай² хуулийн 4.1.2-т заасан аюулд нэрвэгдсэн агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх аливаа арга хэмжээ үр дүнгүй болсон тохиолдолд эрлийн ажлыг зогсоох шийдвэрийг уг агаарын хөлгийг эзэмшигчийн саналыг үндэслэн Засгийн газар гаргана.”

² Улсын нисэхийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2003 оны 23 дугаарт нийтлэгдсэн.

13\27¹ дүгээр зүйл:

“27¹ дүгээр зүйл. Нисэхийн цаг уурын үйлчилгээ

27¹.1.Нисэхийн цаг уурын үйлчилгээг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын харьяа иргэний нисэхийн дүрмээр гэрчилгээжсэн нэгж үзүүлнэ.

27¹.2.Нисэхийн цаг уурын үйлчилгээний баримт бичгийг ус цаг уур, орчны хяналт шинжилгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, Иргэний нисэхийн ерөнхий газар хамтран батална.”

14\32 дугаар зүйлийн 32.3-32.5 дахь хэсэг:

“32.3.Аэродром орчим баригдах, эсхүл суурилагдах барилга, байгууламж, объект нь аэродромын саадыг хязгаарлах гадаргууг нэвтлэх болон шувуу цугларах, татах нөхцөл үүсгэхийг хориглоно.

32.4.Аэродром орчмын саадыг хязгаарлах гадаргуу болон аэродромын аюулгүйн бүсийн газар ашиглалтын хяналтыг аэродромын гэрчилгээ эзэмшигч тогтмол гүйцэтгэх бөгөөд энэ хуулийн 32.3-т заасныг зөрчсөн гэж Иргэний нисэхийн ерөнхий газраас тогтоосон тохиолдолд аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн барилга, байгууламж, объектийг буулгах арга хэмжээг авна.

32.5.Аэродромын үйл ажиллагаа эрхлэгч нь аэродром орчмын зэрлэг амьтан, шувууны аюулын судалгааг 5 жил тутам хийх ба тогтоогдсон эрсдэлийг арилгана.”

15\39¹ дүгээр зүйл:

“39¹ дүгээр зүйл. Иргэний нисэхийн баримт бичиг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

39¹.1.Иргэний нисэхийн баримт бичиг эзэмших хүсэлт гаргах, түүнийг олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хураах харилцааг энэ хуулийн 12.1-д заасан дүрмээр зохицуулна.

39¹.2.Дарга энэ хуулийн 36.2, 36.3-т заасан хяналтын чиглэлээр гэрчилгээ олгох, гэрчилгээний хүчинтэй хугацааг сунгахдаа хууль, дүрмээр тогтоосон шаардлагын хүрээнд баримт бичгийн болон газар дээрх үзлэг шалгалт хийж баталгаажуулснаар шийдвэрлэнэ. Нисэхийн баримт бичигт түүнийг эзэмшигчийн дагаж мөрдөх үйл ажиллагааны нөхцөл, хязгаарлалтыг тогтоож болно.

39¹.3.Хяналтын байцаагч нисэхийн баримт бичиг эзэмшигч хүн, хуулийн этгээд хууль, дүрэм зөрчсөн тохиолдолд иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу албадан хэрэгжүүлэх арга хэмжээ авна.

39¹.4.Хүн, хуулийн этгээд нь иргэний нисэхийн баримт бичгийг олгох, хүчингүй болгох, түдгэлзүүлэхтэй холбоотой гаргасан шийдвэрт даргад гомдол гаргаж болно.

39¹.5.Дарга конвенцод нэгдэн орсон улсаас олгосон хүчин төгөлдөр нисэхийн ажилтны үнэмлэх, гэрчилгээ болон бусад баримт бичгийг баталгаажуулан зөвшөөрч, эсхүл хүлээн зөвшөөрч болно.”

2 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “хүртээмжтэй” гэсний өмнө “тогтвортой,” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалтын “нисэхийн” гэсний дараа “ерөнхий газрын” гэж, 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалтын “нисэхийн” гэсний дараа “дүрэм боловсруулах,” гэж, 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтын “тээвэрлэгчийн” гэсний дараа “хариуцлагын” гэж, 19 дүгээр зүйлийн 19.1.3 дахь заалтын “үзүүлэх” гэсний дараа “, шаардлагатай бол зорчигчийн мэдээллийг хууль тогтоомжид заасны дагуу холбогдох байгууллагуудад хүргүүлэх” гэж, 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн “байгууллагаас” гэсний дараа “холбоогоор болон саатуулагч агаарын хөлгөөс анхааруулга, эсхүл бусад дохиогоор тавьсан” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар тус тус өөрчлөн найруулсугай:

1\1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг:

“1.1.Энэ хуулийн зорилго нь иргэний нисэхийн үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоож, Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалтыг хангуулахад чиглэсэн харилцааг зохицуулах, Олон улсын иргэний нисэхийн тухай Чикагогийн Конвенц \цаашид “конвенц” гэх\ болон Монгол Улс нэгдэн орсон бусад конвенцоор хүлээсэн үүргийн биелэлтийг хангахад оршино.”

2\5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалт:

“5.1.8.“хэрэг” гэж агаарын хөлгийн аюулгүй байдалд нөлөөлж байгаа, эсхүл нөлөөлж болох, ослоос бусад хэрэг явдлыг;”

3\8 дугаар зүйлийн 8.1.9 дэх заалт:

“8.1.9.агаарын хөлгийн осол, хэргийг шинжлэн шалгах алба болон иргэний нисэхийн ерөнхий газрын бүтэц, орон тоо, цалингийн хэмжээг Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын иргэний нисэхийн тухай конвенцод нийцүүлэн батлах;”

4\9-11 дүгээр зүйл:

“9 дүгээр зүйл.Иргэний нисэхийн ерөнхий газар, түүний чиг үүрэг, баталгаа

9.1.Монгол Улсад иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтын тогтолцоог Конвенцын стандарт, зөвлөмжид нийцүүлэн бүрдүүлэх, хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий бие даасан, хараат бус мэргэжлийн байгууллага нь Иргэний нисэхийн ерөнхий газар байна.

9.2.Иргэний нисэхийн ерөнхий газар нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.2.1.Конвенцын хавсралтад нийцүүлэн Иргэний нисэхийн дүрэм, түүнд хамаарах техник, технологийн баримт бичгийг боловсруулах, бүртгүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

9.2.2.Конвенцын хэлэлцэн тохиролцогч улсын иргэний нисэхийн байгууллагатай хамтран ажиллах, мэдээлэл харилцан солилцох;

9.2.3.Иргэний нисэхийн дүрэм болон Конвенцын хавсралтад заасан стандартын зөрүүтэй байдлыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад мэдээлэх;

9.2.4.иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалттай холбоотой аюулгүй байдлын мэдээллийн санг хөтлөх, хамгаалах, дүн шинжилгээ хийх, мэдээллийн санд тулгуурласан эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, холбогдох байгууллагатай мэдээлэл солилцох;

9.2.5.иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн гэрчилгээ, нисэхийн гэрчилгээжсэн ажилтны үнэмлэх, гэрчилгээ, зэрэглэл олгох;

9.2.6.Монгол Улсыг Олон улсын иргэний нисэхийн байгууллагад төлөөлж, тус байгууллагаас баримталж буй бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэх;

9.2.7.олон улсын гэрээ, дотоодын хууль тогтоомжид нийцүүлэн иргэний нисэхийн аюулгүй байдлын, нисэхийн аюулгүйн хамгаалалтын болон агаарын тээврийг хялбаршуулах журмыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих;

9.2.8.Монгол Улсын нутаг дэвсгэр, агаарын зайд нислэг үйлдэх зөвшөөрөл олгох;

9.2.9.Иргэний нисэхийн аюулгүй байдал, нисэхийн аюулгүйн хамгаалалтын эрсдэлд суурилсан хяналт, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх;

9.2.10.иргэний нисэхийн хяналт, шалгалтыг гүйцэтгэх;

9.2.11.хууль, стандарт, шаардлага, журам, зааврыг дагаж мөрдүүлэх зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилгоор хүн, хуулийн этгээдэд хуульд заасны дагуу албадлагын арга хэмжээг авах;

9.2.12.иргэний нисэхийн салбарт сайн дурын болон заавал авах аюулгүй байдлын мэдээлэл цуглуулах, бэлтгэх, солилцох, түгээх, түүнчлэн энэ талаар хүн, хуулийн этгээдтэй хамтран ажиллах.

9.3.Иргэний нисэхийн ерөнхий газар нь нэгдэн орсон олон улсын гэрээ, энэ хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх, иргэний нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтын хяналт, зохицуулалтыг тасралтгүй, үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, санхүүгийн чадамжтай байна.

9.4.Иргэний нисэхийн ерөнхий газар нь иргэний нисэхийн хяналт, зохицуулалтыг хэрэгжүүлэх хүний нөөцийг тогтвор суурьшилтай ажиллуулах, хөгжүүлэх урт хугацааны хүний нөөцийн хөтөлбөртэй байна.

9.5.Иргэний нисэхийн ерөнхий газар нь нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг тасралтгүй хангуулах санхүүгийн нөөцтэй байна. Иргэний нисэхийн ерөнхий газар нь санхүүгийн тайлангаа жил бүр аудитаар баталгаажуулж, цахим хуудастаа ил тод нийтэлнэ.

9.6.Иргэний нисэхийн ерөнхий газрын санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ:

9.6.1.өнгөрөлтийн нислэгээс хураасан агаарын навигацийн үйлчилгээний хураамжийн 15 хувь;

9.6.2.арилжааны агаарын тээврийн үйл ажиллагааны дараах хураамж:

9.6.2.1.олон улсын тогтмол нислэгээр зорчиж буй зорчигчийн тасалбар тус бүрээс 10 төлбөрийн нэгжтэй тэнцэх мөнгөн хураамж;

9.6.2.2.орон нутгийн тогтмол нислэгээр зорчиж буй зорчигчийн тасалбар тус бүрээс хоёр төлбөрийн нэгжтэй тэнцэх мөнгөн хураамж;
Тайлбар: Энэ хуулийн 9.6.2-т заасан төлбөрийн нэг нэгж нэг мянган төгрөгтэй тэнцэнэ.

9.6.3.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын төлбөртэй үйлчилгээнээс төвлөрүүлсэн хураамж;

9.6.4.онцгой нөхцөл үүссэн тохиолдолд улсын төсвөөс хуваарилсан хөрөнгө;

9.6.5.иргэний нисэхийн ерөнхий газрын чадамжийг бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлэх төсөл, хөрөнгө оруулалтын санхүүжилт.

10 дугаар зүйл.Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга, түүний бүрэн эрх

10.1.Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга /цаашид “дарга” гэх/ бөгөөд иргэний нисэхийн хяналтын улсын ерөнхий байцаагч нь иргэний нисэхийн мэргэжлийн дээд боловсролтой, иргэний нисэхийн хяналтын байцаагчид тавигдах шаардлагыг хангасан байна.

10.2.Дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.2.1.иргэний нисэхийн аюулгүй байдлын хяналт, зохицуулалтыг хариуцах;

10.2.2.иргэний нисэхийн хяналтын байцаагчийн эрх олгох, цуцлах;

10.2.3.Иргэний нисэхийн дүрэм, түүнийг дагалдах зөвлөмжийн цуврал, маягт, бүртгэлийн дэвтэр, техник, технологийн баримт бичгийг конвенцод нийцүүлэн батлах, тэдгээрт өөрчлөлт оруулах;

10.2.4.аюулгүй байдлын зөвлөмжийг үндэслэн агаарын хөлгийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

10.2.5.нислэгийн аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй Иргэний нисэхийн дүрмээр зохицуулагдаагүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд тодорхой хугацаатай шийдвэр гаргаж, холбогдох этгээдэд мэдээлэх;

10.2.6.нислэгт тэнцэх чадварт тавигдах шаардлага хангаагүй агаарын хөлгийн нислэгийг зогсоох, зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

10.2.7.хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулж болзошгүй тохиолдолд нислэгийг зогсоох арга хэмжээг авах;

10.2.8.хууль болон албадан хэрэгжүүлэх дүрмийн дагуу мэргэжлийн үнэмлэх, агаарын тээвэрлэгчийн гэрчилгээ, агаарын хөлгийн бүртгэлийн гэрчилгээ, агаарын хөлгийн нислэгт тэнцэх чадварын гэрчилгээ, агаарын хөлгийн радио холбооны гэрчилгээ, аэродромын гэрчилгээ, зөвшөөрөл, болон эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох зэрэг хариуцлагын арга хэмжээ авах;

10.2.9.аюулгүйн үзлэг, хамгаалалт шаардлагатай нисэх буудал болон агаарын навигацийн байгууламжийн жагсаалтыг батлах;

10.2.10.Иргэний нисэхийн дүрэмд заасны дагуу тус дүрмийн шаардлагаас чөлөөлөх;

10.2.11.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын төлбөртэй үйлчилгээний төрөл, төлбөрийн хэмжээг тогтоох;

10.2.12.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлж, олон улсын шаардлагад нийцсэн мэргэшсэн, ур чадвартай хүний нөөцийг томилох, чөлөөлөх;

10.2.13.иргэний нисэхийн хяналт, зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэхэд шаардлагатай санхүү, захиргааны шийдвэр гаргаж, нэгдсэн удирдлагаар хангах;

10.2.14.Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийн радио холбооны гэрчилгээний нөхцөл, шаардлагыг тодорхойлж олгох;

10.2.15.хуульд заасан бусад.

11 дүгээр зүйл.Эрх олгох, шилжүүлэх, итгэмжлэл олгох

11.1.Эрх олгох, шилжүүлэх, итгэмжлэл олгохтой холбоотой журмыг холбогдох олон улсын гэрээ болон хууль тогтоомжид нийцүүлэн дарга батална.

11.2.Дарга иргэний нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтын хяналт шалгалт хийх эрхийг иргэний нисэхийн хяналтын байцаагчид энэ зүйлийн 11.1-т заасан журмын дагуу олгоно.

11.3.Дарга иргэний нисэхийн хяналтыг үр дүнтэй, бүрэн хэрэгжүүлэх зорилгоор энэ зүйлийн 11.1-т заасан журмын дагуу зохих шаардлага хангасан этгээдэд итгэмжлэл олгож болно.

11.4.Дарга энэ зүйлийн 11.2-т заасны дагуу эрх, 11.3-т заасны дагуу итгэмжлэл олгосон нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

11.5.Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлгийг өөр улсад түрээсээр ашиглуулахад дарга тухайн агаарын хөлгийг ашиглах агаарын тээвэрлэгчийн харьяалах улстай конвенцын холбогдох зүйлийн дагуу үүрэг, хариуцлагыг шилжүүлэх гэрээ байгуулна.

11.6.Дарга энэ зүйлийн 11.5 дахь хэсэгт заасны дагуу гэрээ байгуулсан бол Иргэний нисэхийн олон улсын байгууллагад болон агаарын тээвэрлэгчид мэдээлнэ.

11.7.Гадаад улсад бүртгэлтэй агаарын хөлгийг энэ зүйлийн 11.5-д заасан гэрээ байгуулан Монгол Улсын агаарын тээвэрлэгч ашиглах тохиолдолд дарга конвенцын холбогдох зүйлд заасан тухайн агаарын хөлөгт хамаарах үүрэг, хариуцлагыг хүлээнэ.”

5\12 дугаар зүйлийн 12.1.20, 12.1.21 дэх заалт:

“12.1.20.холбоо, навигаци болон ажиглалтын, нислэгийн хөдөлгөөний, хэрэглэлийн нислэгийн журмын, нисэхийн цаг уурын, нисэхийн мэдээллийн, нислэгийн зургийн үйлчилгээний байгууллагыг гэрчилгээжүүлэх;

12.1.21.нисэхийн хангамжийн байгууллагыг гэрчилгээжүүлэх;

12.1.22.агаарын хөлгийн түрээсийн зохицуулалт;

12.1.23.шалгалтын нислэгийн үйл ажиллагаа;

12.1.24.конвенцын хавсралтад оруулсан нэмэлт, өөрчлөлтийн дагуу батлах бусад дүрэм.”

6\14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг:

“14.1.Иргэний нисэхийн ерөнхий газар нь Монгол Улсад бүртгэх агаарын хөлөг, түүний бүрдэл хэсгийн бүртгэлийг хөтөлж, шаардлагатай тохиолдолд агаарын хөлгийн бүртгэл, өмчлөлтэй холбоотой мэдээллийг гаргаж өгнө.”

7\18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг:

“18.2.Гадаадын агаарын тээвэрлэгч нь Монгол Улсын нутаг дэвсгэрт орон нутгийн тогтмол нислэгийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.”

8\25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэг:

“25.2.онцгой байдлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага аюул тулгарсан агаарын хөлөг, нисэх баг, зорчигчдыг эрэн хайх, аврах ажиллагааг тухайн агаарын хөлгөөр үйл ажиллагаа эрхлэгч, эсхүл бүртгэгч улсын эрх бүхий байгууллагатай хамтран иргэний нисэхийн эрэн хайх, аврах ажиллагааны бүсэд гүйцэтгэх бөгөөд энэ бүс нь Монгол Улсын нутаг дэвсгэр болон агаарын зайг хамарна.”

9\38, 39 дүгээр зүйл:

“38 дугаар зүйл.Иргэний нисэхийн хяналтын байцаагчийн бүрэн эрх

38.1.Хяналтын байцаагч нь дараах бүрэн эрхтэй:

38.1.1.хяналт шалгалт хийх зорилгоор иргэний нисэхийн үйл ажиллагаатай холбогдолтой дараах объект, барилга байгууламжид саадгүй нэвтрэх:

38.1.1.1.агаарын хөлөг;

38.1.1.2.аэродром, нисэх буудал;

38.1.1.3.агаарын навигацийн байгууламж;

38.1.1.4.ангар;
38.1.1.5.техникийн үйлчилгээний байгууллага;
38.1.1.6. засварын газар, цех;
38.1.1.7.түлш хадгалах байгууламж;
38.1.1.8.нисэх буудлын перрон;
38.1.1.9.нисэхийн сургалтын байгууллага;
38.1.1.10.агаарын тээвэрлэгч болон нисэхийн баримт бичиг
эзэмшигчийн байр;
38.1.1.11.ачаа, шуудангийн байгууламж, талбай;
38.1.1.12.бусад хамаарал бүхий байгууламж;
38.1.2.хяналт шалгалтын чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор дараах
нисэхийн баримт бичгийг шаардан гаргуулах, систем рүү нэвтрэх:

38.1.2.1.үйл ажиллагааны заавар, журам, зааварчилгаа;
38.1.2.2.техникийн баримт бичиг;
38.1.2.3.ажилтны хувийн хэрэг;
38.1.2.4.олгогдсон гэрчилгээ, зөвшөөрөл, үнэмлэх;
38.1.2.5.агаарын хөлөг болон аюулгүй байдлын хамааралтай
аливаа өгөгдөл, бүртгэл;

38.1.2.6.эдийн засгийн зохицуулалтын дүрмээр шаардах баримт
бичиг;

38.1.2.7.хууль, дүрмийн дагуу шаардсан бусад баримт бичиг;

38.1.3.хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө, хүрээлэн буй орчин
болон нийтийн ашиг сонирхолд илтэд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн
тохиолдолд даргын тогтоосон журмын дагуу хяналтын байцаагч агаарын хөлгийг
саатуулах;

38.1.4.хяналтын байцаагч даргаас олгосон баримт бичгийг
үргэлжлүүлэн ашиглах нь нисэхийн аюулгүй байдал, аюулгүйн хамгаалалтад аюул
учруулж болзошгүй тохиолдолд холбогдох этгээдийн иргэний нисэхийн баримт
бичгийг түр хураах;

38.1.5.хяналт, шалгалтын явцад илэрсэн зөрчил, дутагдлыг таслан
зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар холбогдох байгууллага аж
ахуйн нэгж, иргэн, албан тушаалтанд шаардлага тавьж, хугацаатай үүрэг даалгавар
өгөх;

38.1.6.нисэхийн аюулгүйн хамгаалалт хариуцсан хяналтын байцаагч
нь нисэхийн аюулгүйн хамгаалалтын сорилт хийх;

38.1.7.хуульд нийцээгүй үүрэг, даалгавраас татгалзах;

38.1.8.Зөрчлийн тухай³ хуульд заасан зөрчлийг шалган шийдвэрлэх;

38.1.9.хуульд заасан бусад бүрэн эрх.

38.2.Энэ хуулийн 38.1-т заасан бүрэн эрхийг хяналтын байцаагчид олгох
журмыг дарга батална.

39 дүгээр зүйл.Хяналтын байцаагчийн ажиллах нөхцөл, баталгаа

³ Зөрчлийн тухай /Шинэчилсэн найруулга/, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

39.1.Хяналтын байцаагч дараах цалин хөлс, хангамж, нийгмийн баталгаагаар хангагдана:

39.1.1.хяналтын байцаагчийн цалин хөлс иргэний нисэхийн салбарын адилтгах бусад албан тушаалын цалингаас багагүй байхаар Засгийн газар тогтооно;

39.1.2.хяналтын байцаагчийг мэргэшсэн, тогтвортой ажиллуулах зорилгоор хяналтын байцаагчаар ажилласан хугацааны нэмэгдэл урамшуулал олгоно;

39.1.3.амь нас, эрүүл мэндийг даатгуулна.

39.2.Хяналтын байцаагч түүний эрхийг тодорхой заасан үнэмлэхтэй байна.

39.3.Хяналтын байцаагч дүрэмт хувцас болон хяналт шалгалт хийхэд шаардлагатай тоног төхөөрөмж, багаж, тээврийн хэрэгслээр хангагдсан байна.

39.4.Хяналтын байцаагч батлагдсан мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийн дагуу сургалтад тогтмол хамрагдсан байна.”

4 дүгээр зүйл.Иргэний нисэхийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалтын “нисэхийн мэдээлэл, нисэхийн цаг уурын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах” гэснийг “нисэхийн зураг, нисэхийн мэдээлэл, нисэхийн цаг уурын, хэрэглэлийн нислэгийн журмын үйлчилгээ болон эрэн хайх, авран туслах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл дамжуулах, зохицуулах” гэж, мөн зүйлийн 5.1.5, 8 дугаар зүйлийн 8.1.8, 8.1.10, 8.1.11 дэх заалт, 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт, есдүгээр бүлгийн гарчгийн, 40 дүгээр зүйлийн гарчгийн “зөрчлийг” гэснийг “тохиолдлыг” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.9 дэх заалтын “стандартын суурь түвшнийг хангах зорилгоор энэ хуульд нийцүүлэн гаргасан нисэхийн аюулгүй байдлыг зохицуулах” гэснийг “стандартыг хангах, конвенцын зөвлөмжид нийцүүлэх зорилгоор энэ хуулийн дагуу гаргасан нисэхийн аюулгүй байдал болон аюулгүйн хамгаалалтыг зохицуулах, нийтээр дагаж мөрдөх” гэж, мөн зүйлийн 5.1.20 дахь заалтын “зөрчилд” гэснийг “тохиолдолд” гэж, 7 дугаар зүйлийн 7.1.5 дахь заалтын “асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын” гэснийг “ерөнхий газрын” гэж, 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтын “зохицуулалтыг” гэснийг “зохицуулалтын дүрмийг батлах,” гэж, 8.1.6 дахь заалтын “олон улсын хуваарьт” гэснийг “агаарын тээврийн олон улсын тогтмол” гэж, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсгийн “бүртгүүлнэ.” гэснийг “бүртгүүлж, үндэсний харьяаллын болон бүртгэлийн таних тэмдэг авна.” гэж, мөн хэсгийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийн “асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагаас” гэснийг “ерөнхий газраас” гэж, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “хураамжийн орлогоор санхүүжүүлнэ” гэснийг “хураамжаас санхүүжүүлнэ. Агаарын навигацийн хураамжийг иргэний нисэхийн аюулгүй байдлыг хангуулахад зарцуулах бөгөөд улсын төсөвт төвлөрүүлэхийг хориглоно” гэж, 40 дүгээр зүйлийн 40.1, 41 дүгээр зүйлийн 41.3, 47 дугаар зүйлийн 47.4 дэх хэсгийн “байгууллагад” гэснийг “албанд” гэж, 40 дүгээр зүйлийн 40.2, 42 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 42.1, 42.2, 42.3, 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсгийн “байгууллага” гэснийг “алба” гэж, 40 дүгээр зүйлийн 40.4 дэх хэсэг, 43 дугаар зүйлийн 43.4.6 дахь заалтын “байгууллагын” гэснийг “албаны” гэж, 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийн “байгууллагыг” гэснийг “албыг” гэж, 47 дугаар зүйлийн 47.2 дахь хэсгийн “асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага” гэснийг “ерөнхий газар” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрөөс дагаж мөрдөнө.

Гарын үсэг